



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/077/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ӨСӨХЖАРГАЛ ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/077/НА-СТА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын ерөнхий газраас 41,910.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн зөн ОУБ-аас 3,620.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, төгсөгчдийн хандиваар 8,924.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, Юнивишн ХХК-аас 9,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн ИТХ-ын 2025 оны 28 дугаар тогтоолоор 14,562.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдаж, данс бүртгэлээс хассан, сумын ИТХ-ын 2025 оны 34 дүгээр тогтоолоор 92 нэр төрлийн 38,761.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	311,821,278.51	347,582,272.41
312	Банканд байгаа бэлэн мөнгө		311,821,278.51	347,582,272.41
3121	Төгрөг		311,821,278.51	347,582,272.41
31211	Төрийн сангийн харилцах		311,821,278.51	347,582,272.41
35	БАРАА МАТЕРИАЛ	6	143,299,546.82	178,141,101.64
351	Түүхий эд материал		21,666,240.79	28,888,459.07
3511	Тусгай зориулалттай материал		21,666,240.79	28,888,459.07
3513	Эм боох материал		30,000.00	30,000.00
353	Бэлэн бүтээгдэхүүн		1,487,100.00	712,000.00
354	Хангамжийн материал		120,146,206.03	148,540,642.57
3541	Бичиг хэргийн материал			71,000.00
3542	Аж ахуйн материал		62,085,345.31	66,903,381.85
3543	Сэлбэг хэрэгсэл		6,721,100.00	7,072,000.00
3545	Барилгын засварын материал		12,223,000.00	12,291,000.00
3546	Хүнсний материал		140,700.00	199,000.00
3547	Бусад хангамжийн материал		38,976,060.72	62,004,260.72
36	НӨӨЦИЙН БАРАА			
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		455,120,825.33	525,723,374.05
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	2,145,935,931.34	2,080,231,568.28
392	Биет хөрөнгө		2,113,692,336.44	2,048,938,178.86
39201	Барилга, байгууламж, орон сууц		2,030,135,596.00	2,030,135,596.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(281,039,269.88)	(332,993,154.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		14,562,500.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл		(13,348,958.26)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		350,113,956.41	398,242,428.90
39206	Хуримтлагдсан элэгдэл		(147,439,490.31)	(205,925,382.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		166,920,843.97	172,962,871.97
39208	Хуримтлагдсан элэгдэл		(58,519,506.42)	(68,683,296.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө		64,689,078.00	71,659,078.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(32,914,315.66)	(38,372,121.81)
39217	Ном		20,531,902.59	21,912,159.19
393	Биет бус хөрөнгө		32,243,594.90	31,293,389.42
39301	Программ хангамж		6,001,027.55	6,001,027.55
39302	Хуримтлагдсан элэгдэл		(4,021,432.65)	(4,971,638.13)
39303	Бусад биет бус хөрөнгө		30,264,000.00	30,264,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,145,935,931.34	2,080,231,568.28
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,601,056,756.67	2,605,954,942.33
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР			
51	Засгийн газрын хувь оролцоо		2,601,056,756.67	2,605,954,942.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		756,321,843.72	756,321,843.72
512	Хуримтлагдсан үр дүн		235,030,868.49	239,929,054.15
5121	Өмнөх үеийн үр дүн		235,030,868.49	235,030,868.49
5122	Тайлант үеийн үр дүн			4,898,185.66
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,609,704,044.46	1,609,704,044.46
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,601,056,756.67	2,605,954,942.33
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,601,056,756.67	2,605,954,942.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,650,862,128.48	1,836,228,961.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,468,064,500.00	1,647,737,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,468,064,500.00	1,647,737,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			1,640,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			1,640,536.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		182,797,628.48	186,850,725.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		182,797,628.48	186,850,725.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		198,339,384.50	70,677,263.28
120	Нийтлэг татварын бус орлого		198,339,384.50	70,677,263.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		13,750,300.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		13,750,300.00	
120009	Бусад орлого		60,233,608.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		98,470,046.00	63,455,045.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		25,885,430.50	7,222,218.28
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,849,201,512.98	1,906,906,224.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,606,032,268.74	1,902,008,039.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,566,730,768.74	1,840,364,339.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,025,750,272.81	1,223,423,182.20
210101	Үндсэн цалин		662,475,961.95	763,719,982.31
210102	Нэмэгдэл		323,453,610.86	394,919,749.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт			34,102,000.00
210104	Урамшуулал		39,820,700.00	30,681,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		124,142,349.68	147,607,638.87
210201	Тэтгэврийн даатгал		84,222,221.84	100,597,104.27
210202	Тэтгэмжийн даатгал		10,234,084.04	12,246,728.49
210203	ҮОМШӨ-ний даатгал		5,117,042.50	6,077,824.29
210204	Ажилгүйдлийн даатгал		4,887,763.93	5,708,521.82
210205	Эрүүл мэндийн даатгал		19,681,237.37	22,977,460.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		170,994,628.48	172,520,725.71
210301	Гэрэл, цахилгаан		12,058,428.48	14,287,522.51
210302	Түлш, халаалт		157,756,200.00	157,323,203.20
210303	Цэвэр, бохир ус		1,180,000.00	910,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		446,000.00	
210402	Тээвэр, шатахуун		446,000.00	
2105	Нормативт зардал		38,968,500.00	53,446,900.00
210502	Хоол, хүнс		38,968,500.00	53,446,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		124,550.00	8,396,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		124,550.00	
210604	Урсгал засвар			8,396,910.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		14,742,395.94	22,203,736.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,502,900.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		12,239,495.94	22,203,736.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		191,562,071.83	212,765,246.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		73,383,810.34	38,891,601.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,304,550.00	7,486,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		109,873,711.49	166,386,794.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		39,301,500.00	61,643,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		39,301,500.00	61,643,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		39,301,500.00	61,643,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,606,032,268.74	1,902,008,039.33
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		243,169,244.24	4,898,185.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		68,472.13	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		68,472.13	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(68,472.13)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		243,100,772.11	4,898,185.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,664,612,428.48	1,836,228,961.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,750,300.00	
120	Нийтлэг татварын бус орлого	13,750,300.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,750,300.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,750,300.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,650,862,128.48	1,836,228,961.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,468,064,500.00	1,647,737,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,468,064,500.00	1,647,737,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,640,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,640,536.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182,797,628.48	186,850,725.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182,797,628.48	186,850,725.71
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,473,224,711.91	1,762,640,967.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,473,224,711.91	1,762,640,967.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,434,281,811.91	1,701,772,367.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,021,408,001.92	1,223,688,122.66
210101	Үндсэн цалин	647,683,042.85	765,735,190.84
210102	Нэмэгдэл	337,755,684.07	400,795,567.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		31,925,200.00
210104	Урамшуулал	35,969,275.00	25,232,164.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,444,505.18	146,780,038.41
210201	Тэтгэврийн даатгал	86,329,136.76	100,636,690.39
210202	Тэтгэмжийн даатгал	10,255,059.86	12,024,095.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,127,624.70	5,955,593.75
210204	Ажилгүйдлийн даатгал	4,944,208.70	5,604,052.91
210205	Эрүүл мэндийн даатгал	19,788,475.16	22,559,605.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,994,628.48	172,850,725.71
210301	Гэрэл, цахилгаан	12,058,428.48	14,287,522.51
210302	Түлш, халаалт	157,756,200.00	157,323,203.20
210303	Цэвэр, бохир ус	1,180,000.00	1,240,000.00
2105	Нормативт зардал	37,510,900.00	53,948,400.00
210502	Хоол, хүнс	37,510,900.00	53,948,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,803,000.00	14,000,000.00
210604	Урсгал засвар	11,803,000.00	14,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,152,711.33	22,905,135.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,502,900.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,649,811.33	22,905,135.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,968,065.00	67,599,946.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,991,065.00	57,622,146.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,977,000.00	9,977,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,942,900.00	60,868,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,942,900.00	60,868,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,942,900.00	60,868,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	191,387,716.57	73,587,993.90
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,276,360.00	37,827,000.00
225106	Дотоод эх үүсвэрээр Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,276,360.00	37,827,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(35,276,360.00)	(37,827,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	156,111,356.57	35,760,993.90
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		311,821,278.51
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		347,582,272.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	235,030,868.49	2,601,056,756.67
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			4,898,185.66	4,898,185.66
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	239,929,054.15	2,605,954,942.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	2,171,317,100.00	1,836,228,961.71	335,088,138.29	84.6
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,981,933,700.00	1,649,378,236.00	332,555,464.00	83.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,669,607,100.00	1,647,737,700.00	21,869,400.00	98.7
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	310,685,900.00			
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,640,700.00	1,640,536.00	164.00	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,640,700.00	1,640,536.00	164.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	189,383,400.00	186,850,725.71	2,532,674.29	98.7
132001	Орон нутгийн төсвөөс	189,383,400.00	186,850,725.71	2,532,674.29	98.7
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,867,109,200.00	1,836,228,961.71	30,880,238.29	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,171,317,100.00	1,762,640,967.81	408,676,132.19	81.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,105,302,300.00	1,701,772,367.81	403,529,932.19	80.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,525,440,600.00	1,223,688,122.66	301,752,477.34	80.2
210101	Үндсэн цалин	930,545,800.00	765,735,190.84	164,810,609.16	82.3
210102	Нэмэгдэл	570,779,800.00	400,795,567.00	169,984,233.00	70.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт		31,925,200.00	(31,925,200.00)	
210104	Урамшуулал	24,115,000.00	25,232,164.82	(1,117,164.82)	104.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,123,400.00	146,780,038.41	44,343,361.59	76.8
210201	Тэтгэврийн даатгал	129,963,900.00	100,636,690.39	29,327,209.61	77.4
210202	Тэтгэмжийн даатгал	15,289,900.00	12,024,095.47	3,265,804.53	78.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,644,900.00	5,955,593.75	1,689,306.25	77.9
210204	Ажилгүйдлийн даатгал	7,644,900.00	5,604,052.91	2,040,847.09	73.3
210205	Эрүүл мэндийн даатгал	30,579,800.00	22,559,605.89	8,020,194.11	73.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,383,400.00	172,850,725.71	2,532,674.29	98.6

210301	Гэрэл, цахилгаан	16,820,100.00	14,287,522.51	2,532,577.49	84.9
210302	Түлш, халаалт	157,323,300.00	157,323,203.20	96.80	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,240,000.00	1,240,000.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	70,175,300.00	53,948,400.00	16,226,900.00	76.9
210502	Хоол, хүнс	70,175,300.00	53,948,400.00	16,226,900.00	76.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	14,000,000.00		100.0
210604	Урсгал засвар	14,000,000.00	14,000,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,243,400.00	22,905,135.03	8,338,264.97	73.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,243,400.00	22,905,135.03	8,338,264.97	73.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,936,200.00	67,599,946.00	30,336,254.00	69.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,934,200.00	57,622,146.00	30,312,054.00	65.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,002,000.00	9,977,800.00	24,200.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,014,800.00	60,868,600.00	5,146,200.00	92.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,014,800.00	60,868,600.00	5,146,200.00	92.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,014,800.00	60,868,600.00	5,146,200.00	92.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		37,827,000.00	(37,827,000.00)	
	Дотоод эх үүсвэрээр		37,827,000.00	(37,827,000.00)	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		37,827,000.00	(37,827,000.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,171,317,100.00	1,800,467,967.81	370,849,132.19	82.9
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		311,821,278.51	(311,821,278.51)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		347,582,272.41	(347,582,272.41)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1		
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	44	44		
6	Удирдах ажилтан	3	3		
7	Гүйцэтгэх ажилтан	27	27		
8	Үйлчлэх ажилтан	14	14		
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	385	385		
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	385	385		
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 92,489.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Барилга дансанд бүртгэлтэй 46,000.0 мянган төгрөгийн дээврийн их засварыг капиталжуулалгүйгээр тусдаа 1 хөрөнгө мэтээр бүртгэсэн,
- Гүйлгээ баланс дахь хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн дүн нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас 46,489.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын

санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 19¹-д “ ... хөрөнгөд тодорхой хэсгийг нэмэх ... буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Толилуулаа” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **105,051.0** мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 1,293.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 6,449.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 97,308.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **7,742.6** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,317.7 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Багшийн ажлын үнэлгээнд хамрагддаггүй дотуур байрны багш Б.Ариунзулд 848.4 мянган төгрөгийн, сургалтын менежер Б.Мартад 445.2 мянган төгрөгийн нийт 1,293.6 мянган төгрөгийн багшийн гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 “багшийн ажлын үнэлгээний үр дүн нь **багшид улирлын мөнгөн урамшуулал олгох үндэслэл болно**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 16 ажилтанд 6,449.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Байгууллага нь өөрийн бүх үндсэн хөрөнгийн өртөг зардлыг тэдгээрийн гарсан тэрхүү цаг хугацаанд үнэлнэ. Эдгээр өртөг зардал нь үндсэн хөрөнгийн зүйлсийг худалдан авах буюу барьж байгуулахад анх гарсан өртөг зардал болон хөрөнгөд тодорхой хэсгийг нэмэх, заримыг сольж орлуулах буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 81 нэр төрлийн 97,308.4 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.38 (ж) *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоосон тохиолдолд хөрөнгийг данснаас хасаж, уг тогтоосон үнээр шинэ хөрөнгө хүлээн зөвшөөрнө. Мөн уг хөрөнгийн цаашид ашиглагдах хугацааг шинэчлэн тогтоож, элэгдэл байгуулна”* гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглах хугацааг сунган бүртгэл тайланд тусгах зөвлөмж хүргүүлээ.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Барилгыг капиталжуулахдаа буруу бүртгэсэн	1	46,000.0			1	46,000.0	1	46,000.0				
Гүйлгээ баланс болон үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлүүд зөрүүтэй	1	46,489.0			1	46,489.0	1	46,489.0				
Дүн	2	92,489.0			2	92,489.0	2	92,489.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багшийн гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал илүү бодож олгосон	1	1,293.6	1	1,293.6								
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан бодож олгосон	1	6,449.0			1	6,449.0						
Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1	97,308.4					1	97,308.4				
Дүн	3	105,051.0	1	1,293.6	1	6,449.0	1	97,308.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Дүн								
Нийт дүн								

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			